

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.09.29

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Хятадын хувьцаанууд энэ онд хурдтай өсөж, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна.
- Биткойн 109,500 ам.долларт унаж, хөрөнгө оруулагчид алт, мөнгөтэй хамт 10%-ийг хуваарилахаар төлөвлөж байна.
- АНУ-ын ДНБ 3.8%-иар өссөн, инфляц тогтвортой, хувийн хэрэглээ нэмэгдэж байгаа нь зах зээлийн дэмжлэг болж байна.
- БНХАУ-д дотоодын мөнгөн нийлүүлэлт өсөж, хүүгийн түвшин бага байгаагаас хөрөнгө оруулагчид илүү эрсдэлтэй, өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтыг сонгож байна.
- Хиймэл оюун ухааны стартапуудын амжилттай нээлт болон Бээжингийн өрсөлдөөнийг багасгах бодлого нь технологийн салбар дахь хөрөнгө оруулалтын урсгалыг идэвхжүүлж байна.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна

БИТКОЙНЫ ХАНШИЙН ТААМАГЛАЛ





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.09.22-09.26

АНУ-ЫН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД УНАЛТТАЙ ХААГДЛАА

Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын хувьцааны зах зээл уналттай хаагдсан нь Fed-ын албан тушаалтнуудын болгоомжтой мэдэгдэлтэй холбоотой байлаа. Nasdaq Composite индекс 0.65%-иар буурч, Russell 2000 индекс наймдугаар сарын эхээс хойш анх удаа долоо унасан долоо хоног байлаа. Эрчим хүчний сектор нефтийн үнийн өсөлтөд дэмжигдэн өссөн бол бусад секторууд голдуу уналттай байлаа.

8-Р САРД ИНФЛЯЦ БАРАГ Л ӨӨРЧЛӨГДСӨНГҮЙ

Наймдугаар сард инфляц бараг өөрчлөгдөөгүй байна. Fed-ын гол үзүүлэлт болох Core PCE индекс сарын өсөлт 0.2%, жилийн өсөлт 2.9%-тай гарч, урьдчилсан таамгуудтай нийцжээ. Хувийн хэрэглээ 0.6%-иар, орлого 0.4%-иар өссөн нь таамгаас бага зэрэг өндөр байв.

АНУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ 3.8% ТЭЛЖЭЭ

Хоёрдугаар улирлын ДНБ 3.8%-иар өссөн нь өмнөх 3.3%-ийн урьдчилсан таамгаас өндөр гарчээ. Өсөлтийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь хувийн хэрэглээний нэмэгдэл байв.

S&P500 ИНДЕКС 7,000 ХҮРЧ ЧАДАХ УУ? (BMO CAPITAL MARKETS)

Эдийн засгийн тогтвортой байдал: АНУ-ын хөдөлмөрийн зах зээл, хэрэглээний эрэлт сулраагүй нь S&P 500-ыг дэмжиж байна.

Тарифын нөлөө хязгаарлагдмал: Инфляцын дарамт бодитоор бага, хөрөнгө оруулагчдын айдсыг бууруулж байна.

Салбарын тэнцвэржилт: Том технологийн хувьцааны ноёрхол буурч, бусад салбаруудын оролцоо өсч байна.

S&P500 ИНДЕКСИЙН ХАНШИЙН ТААМАГЛАЛ



 Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.09.22 – 09.26

БНХАУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ХОЛИМОГ ХӨДӨЛГӨӨНИЙГ ҮЗҮҮЛЛЭЭ

Өнгөрсөн долоо хоногт хөрөнгийн зах зээлийн индексүүд харилцан адилгүй чиглэлтэй хөдөлгөөнүүд үзүүлээ. Onshore зах зээлийн гол индекс CSI 300 1.07%-иар өссөн бол Shanghai Composite индекс 0.21%-иар нэмэгдэв. Харин Хонконгийн Hang Seng индекс 1.57%-иар буурсан байна. Долоо хоногийн турш гол эдийн засгийн үзүүлэлт болон компанийн орлогын тайлан гарсангүй тул хөрөнгө оруулагчдын хувьд шинэ мэдээлэл хомс байлаа.

ЭДИЙН ЗАСАГ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮЧИН ЗҮЙЛС ЗАХ ЗЭЭЛД ЭЕРЭГЭЭР НӨЛӨӨЛЛӨӨ

Дотоодын мөнгөн нөөц буюу мөнгөний нийлүүлэлт өсөж байгаа, хүүгийн түвшин бага байгаа орчин нь хөрөнгийн зах зээлийн идэвхийг дэмжиж байна. Айл өрхүүд хуримтлагдсан хөрөнгөөрөө өндөр өгөөж эрэлхийлж, илүү эрсдэлтэй хөрөнгө оруулалтуудыг сонгож байна.





























Дотоодын хиймэл оюун ухааны стартапуудын амжилттай нээлтүүд болон Бээжингийн “өрсөлдөөнийг багасгах” кампанит ажил нь хөрөнгө оруулагчдын эрсдэлтэй хөрөнгө оруулалтад чиглэсэн хандлагыг нэмэгдүүлж, технологийн салбар дахь хөрөнгө оруулалтын урсгалыг идэвхжүүлж байна.

Эдийн засгийн өсөлт удааширч, дефляцийн дарамт үргэлжилж буй ч зах зээлд эерэг хандлага хадгалагдаж байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын эрсдэлд дасан зохицох хандлагатай уялдаж байна.

HANG-SENG ИНДЕКСИЙН ХАНШИЙН ТААМАГЛАЛ



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
 marti	 FIREFLY  GENFIT	 AutoZone	 Micron  AAR  WORTHINGTON  MillerKnoll  AYTU	 CINTAS  UEC  THOR	 kb HOME  H.B. Fuller  STITCH FIX  Steelcase  WORTHINGTON STEEL	 accenture  CARMAX  BlackBerry  JABIL  TD SYNEX  LuxExperience	 COSTCO WHOLESALE  CONCENTRIX  LEGACY EDUCATION  LightPath	 KNOT

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday	Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 CARNIVAL CORPORATION & PLC	 Progress  Jefferies  VAIL RESORTS  inventiva	 Lamb Weston  PAYCHEX  UNFI	 Nike	 Acuity Brands  CONAGRA  rezolve  RPM  NOVAGOLD  EM Cal-Maine Foods, Inc.	 angiodynamics		

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers